



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Г Өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай Г  
хүрээнд гаргаж буй энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот девелопмент” ХК-ийн өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргаж буй 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 8,430,169 /найман сая дөрвөн зуун гучин мянга нэг зуун жаран ес/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн, тус компанийн нийт гаргасан хувьцааг 8,470,054 /найман сая дөрвөн зуун далан мянга тавин дөрөв/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-г үүрэг болгож, нэмж гаргаж буй энгийн хувьцааг үнэт цаас гаргагчийн тодорхойлсон хувьцаа эзэмшигчийн өмчлөлд бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Хот девелопмент” ХК /Н.Батгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

